


ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ


Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.7%, 2020 онд: +6.3%  
Инфляци: 2019 онд: +8.5%, 2020 онд: 7.5%

Урсгал тэнцэл: 2019 онд: ДНБ-ий -9.6%, 2020 онд: -13%-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2019 оны тайланд тоймлосон байна.

ДНБ-ий өсөлт: 2019 онд: +6.3%  
Инфляци: 2019 онд: +7.1%,


ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2019 онд: -10.8%- Олон улсын валютын сан (ОУВС)-аас гаргадаг (Дэлхийн эдийн засгийн төлөв байдлын судалгаа, 2019 он) тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <http://bit.ly/2zsmvYo>

**ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦИ, ГАДААД ХУДАЛДАА**

**Төсвийн тэнцэл 5-р сарын байдлаар 146 тэрбум төгрөгийн ашигтай гарав.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өнгөрсөн жилийн мөн үеэс 75.2 хувиар, зарлага 70.5 хувиар тус тус буурсан бол төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 146 тэрбум төгрөгийн ашигтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 100.6 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас 10 төгрөгөөр нэмэгдлээ.**

Тавдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 239 төгрөг буюу 10 хувиар нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 10 төгрөг буюу 0.39 хувиар нэмэгдэж 2645.16 төгрөг болов. 4-р сард гадаад валютын нөөц 3.7 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 26.1 хувь нэмэгдсэн байна.




**Инфляцийн түвшин 7.9%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2019 оны 5-р сарын байдлаар өмнөх сараас 1.4 хувиар өсч, өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар, оны эхнээс 4.2 хувь өсөв. 7.9 хувиар хувиар өсөхөд хүнсний бараа, орон сууц, ус, цахилгаан, эм тарианы үнийн дүн нэмэгдсэн нь нөлөөлжээ.



**Гадаад худалдааны тэнцэл 948 сая.ам доллар болов.**

2019 оны тавдугаар сарын байдлаар нийт барааны эргэлт 5578 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 10.1 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 13.1 импорт өмнөх оны мөн үеэс 6.2 хувиар өсч гадаад худалдааны тэнцэл 948 сая ам.долларын ашигтай гарав.



## 5-Р САРЫН ОНЦЛОХ: МУ-ЫН НИЙТ ГАДААД ӨР

Эх сурвалж: [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)

2019 оны нэгдүгээр улирлын байдлаар Засгийн газрын нийт гадаад өр 7.2 тэрбум ам.доллар, Монгол Улсын нийт гадаад өрийн үлдэгдэл 29.5 тэрбум ам.доллар болсон байна. Энэ нь өмнөх улирлаас ЗГ-ын өр 1 хувь (79.7 сая ам.доллар), Улсын нийт гадаад өр 3% (778.6 сая ам.доллар)-иар тус тус өссөн байна.

Харин төв банкны өр 2% буюу 42.1 сая ам.доллараар өссөн бол хадгаламжийн байгууллагуудын өр 8% буюу 173.1 сая ам.доллараар нэмэгджээ. Нийт гадаад өрийн 25%-ийг засгийн газрын өр, 7%-ийг Төв банкны өр, 8%-ийг хадгаламжийн байгууллагуудын өр, 28%-ийг бусад салбаруудын өр, 32%-ийг компани хоорондын зээллэгийн өр тус тус эзэлж байна.

## САРЫН ОНЦЛОХ

**ЧАНАРГҮЙ ЗЭЭЛИЙН 85 ХУВИЙГ ААН-ҮҮДИЙН ЗЭЭЛ ЭЗЭЛЖ БАЙНА.**

- Зээлийг чанараар нь авч үзвэл нийт зээлийн 83.4 хувийг жирийн зээл, хугацаа хэтэрсэн зээл 5.6 хувийг, чанаргүй зээл 11.1 хувийг тус тус эзэлж байна. Хугацаа хэтэрсэн зээл өмнөх сараас 13 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн бол чанаргүй зээл 84.5 тэрбум төгрөгөөр өсөөд байна. Хугацаа хэтэрсэн зээлийг салбараар авч үзвэл барилгын салбар дахь зээл хамгийн их 29 хувийг эзэлж байна. Нийт хугацаа хэтэрсэн зээлийн 79, чанаргүй зээлийн 85 хувийг хувийн байгууллагууд буюу ААН-үүдийн авсан зээл эзэлж байна. Ипотекийн зээлийн өрийн үлдэгдэл энэ сарын байдлаар 4.4 их наяд төгрөг, нийт зээлдэгчдийн тоо 91.146-д хүрэв.

**ДЭЛХИЙН ӨРСӨЛДӨХ ЧАДВАРЫН ТАЙЛАНД МОНГОЛ УЛС 63 УЛСААС 62-РТ ЭРЭМБЭЛЭГДЭВ.**

- Дэлхийн өрсөлдөх чадварын төвөөс гаргадаг "Дэлхийн өрсөлдөх чадварын жилийн тайлан 2019" тайлангийн үр дүнг танилцуулав. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв Монгол Улсын өрсөлдөх чадварыг дэлхийн улсуудтай харьцуулж гаргадаг дээрх байгууллагатай 2010 оноос эхлэн хамтран ажиллаж Монгол Улсын мэдээллүүдийг бэлтгэн явуулдаг. Энэ жил өрсөлдөх чадвараар Сингапур, Хонгконг, АНУ зэрэг улс тэргүүлсэн бол Аргентин, Монгол, Венесуэл улсууд сүүлийн байруудад орсон байна. Харин манай хоёр хөрш БНХАУ 14-т, ОХУ-45-т эрэмбэлэгджээ. Манай улсын хувьд, үнэ ханшийн дэд бүлгийн үзүүлэлт хамгийн өндөр буюу дээгүүр гарчээ. Монгол Улс өнгөрсөн жилийн тайланд эдийн засгийн чадавхаар 48-рт эрэмбэлэгдэж байсан бол энэ жил 58-рт болж шат буурсан. Ингэж буурахад урсгал тэнцэл, ил тод байдал, тэтгэврийн сантай холбоотой үзүүлэлтүүд муудсан нь нөлөөлжээ. Мөн хөдөлмөр эрхлэлт, бизнесийн эрхзүй, эрүүл мэнд, хүрээлэн буй орчин, боловсролын бүлгүүд буурсан нь нөлөөлсөн байна.

Эх сурвалж:

1. Статистикийн бюллетень, 5-р сар 2019 он, Үндэсний статистикийн хороо
2. Статистикийн бюллетень, 5-р сар 2019 он, Монголбанк
3. [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn).